



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018.02.13 № 272

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
П.БАТХҮЛЭГ ТАНАА

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын
2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  С.ЭНХБААТАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018-02-13 № 273

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлаг

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

Б.Баттуяа

Дэд дарга, тэргүүлэх аудитор
ерөөний утас: 327744

Ц.Бат-Өлзий

Санхүүгийн аудитын II хэлтсийн
дарга бөгөөд аудитын
менежер

ерөөний утас: 315558

Д.Энхдалай

Ахлах аудитор
Утас 315093

ТАБ-ын хаяг: Нийслэл дэх
Төрийн аудитын газар

Байршил: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1,
Амарын гудамж 2, Соёлын төв
өргөө, "Г" корпус, 4-5 дугаар
давхар

Вэб: www.city.audit.mn

2018 оны 02 дугаар сарын 13

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Менежментийн захидал

Хавсралт 5: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 6: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын их хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2-д Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд (НТАГ-2017/228/СТА-ТШЗ) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэл дэх Төрийн аудитын газрын санхүүгийн аудитын II хэлтсийн ахлах аудитор Д.Энхдалай 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 12-ны хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 28 тоот албан бичгээр Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 2 дугаар сарын 13-нд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын удирдлагад хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын төсвийн захирагч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын чиг үүргийг тус байгууллагын дүрэмд “Хөдөлмөрийн зах зээлийг уялдуулан зохион байгуулж нийслэлийн хүн амын ажилгүйдэл, ядуурлыг бууруулах ажилгүйчүүд, оюутан залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа болон хөдөлмөр боловсролын хүмүүжил олгож, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлснээр хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг төлөвшүүлэх замаар нийслэлийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоо хэрэгжүүлэн ажиллах.”, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн “Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, бичил бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор “Бичил зээлийн сан” байгуулж, үйл ажиллагааг явуулах зорилт”-ын хүрээнд “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;” гэж тодорхойлсон байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус байгууллага нь Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаас санхүүжиж, санхүүжилтийг нийслэлийн төрийн сангаар дамжуулан олгожээ.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллажээ.

Тус байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг

оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Acolous" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Тус газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед "бага" гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу нийслэлийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тус байгууллагын 2017 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 569.1 мянган төгрөг байсан бол нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаас урсгал зардалд 694 489.4 мянган төгрөг, зээл, зээлийн хүүгийн орлого 274 140.5 мянган төгрөг, смарт карт борлуулсаны шимтгэл 2 304.0 мянган төгрөгийн орлого олж нийт 970 933.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Үүнээс үйл ажиллагааны зардалд 732 199.8 мянган төгрөг зарцуулж, 2 236.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээс зарцуулж, төсвийн үлдэгдэл 236 999.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, нэмэлт санхүүжилтээс 67.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 11 дүгээр сард нийцлийн аудит хийгдсэн болно.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв

Зээлийн хүүгийн орлогыг тооцож бүртгээгүй, төвлөрүүлээгүй, ашиглалтанд байгаа хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, тайлан буруу илэрхийлэгдэх, зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Тус газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1 471 917.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, НДШ, тээвэр шатахууны зардал зэрэг дансын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт мөнгөн хөрөнгийн 78.7%, нийт зардлын 31.0%, нийт хөрөнгийн 29.2%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

1. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц 20 372.5 мянган төгрөгийн материаллаг алдаа илэрсэн. Үүнд:

- Тайлант оны 20 214.8 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тооцож бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.4 заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Хууль, тогтоомж, Сангийн сайдын баталсан заавар, журам, гэрээний холбогдох заалтыг зөрчсөн 14 345.9 мянган төгрөгийн материаллаг бус алдаа илэрсэн. Үүнд:

- Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлого 13 157.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй нь “Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ”-ний 4 дүгээр зүйл Хоршооны эрх, үүрэг, 4.5 дахь заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Ашиглалтанд байгаа 4 нэр төрлийн 111.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.4 дэх заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн.

- Бараа материалын дансанд 1 076.7 сая төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар илэрсэн хууль, тогтоомжийн холбогдох заалтыг зөрчсөн 14 345.9 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулаагүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зарим хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй, эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахгаар тогтов.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2017 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах” нийслэлийн хөтөлбөрийн нийт 122 хоршоогоор дамжуулан олгосон зээлийн үлдэгдэл 14 166 800.0 мянган төгрөг байна (оны эхэнд 14 307 800.0 мянган төгрөг байснаас 141 000.0 мянган төгрөг төлөгдсөн). Хөтөлбөрийн зээлийг дамжуулан олгосон 16 хоршооны 2 652 200.0 мянган төгрөгийн зээлийн гэрээний хугацаа дуусаагүй, 85 хоршооны 2015 онд 2 жилийн хугацаатай байгуулсан, хугацаа дууссан 9 682 100.0 мянган төгрөгийн зээлийн гэрээг хоршоодын хүсэлтийг харгалзан үзэж сунгасан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 20 хоршооны (1 840 500.0 мянган төгрөгийн зээлийг дамжуулан олгосон) зөрчил, дутагдлыг арилгуулахаар үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, мэдээ, тайлан гаргаж ирүүлдэггүй, зээл, зээлийн хүүг графикын дагуу төлөөгүй, бичиг баримтын зөрчилтэй 2 хоршооны (133 000.0 сая төгрөгийн зээлийг дамжуулан олгосон) үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Цаашид эдгээр 22 хоршооны дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлтөнд эрсдэл үүсэх магадлалтай тул тодорхой арга хэмжээ авч, зээл, зээлийн хүүг гэрээний дагуу төвлөрүүлэх, хоршоодын гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 34 560.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 20 214.8 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 13 157.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 188.5 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 1 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал, дүгнэлт

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 7 хуудас, менежментийн захидал 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.


АУДИТЫН ТАЙЛАНГ

Хянасан:
Дэд дарга, тэргүүлэх аудитор

Санхүүгийн аудитын II хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Б.Баттуяа

Ц.Бат-Өлзий

Д.Энхдалай

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Г.Амарын гудамж,
Соёлын төв өргөө, "Г" корпус, 5 давхар
Утас/Факс: (976-11) 32-97-52
<http://www.ubbirj.ub.gov.mn>

2018.02.08 № 42

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тус газрын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийн дагуу залруулан ажиллах болно.

ДАРГА

П. БАТХҮЛЭГ



**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Бараа материал..... 2

Асуудал 2
Бараа материал..... 2-3

Менежментийн захидал

Нийслэл дэх Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийн менежментийн захидлыг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэл дэх Төрийн аудитын газрын энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Орлого

Тэргүүлэх ач олбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлого 13 157.4 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй нь Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4 дүгээр зүйл. Хоршооны эрх, үүрэг 4.5 *"Сангийн эх үүсвэрийн хүүг байршуулсан хөрөнгийн дүнгээс жилийн 1%-иар тооцож, эх үүсвэр байршуулснаас хойш сар бүр хүүг тооцож дараа сарын 05-ны дотор төлнө."* заалтыг зөрчсөн;
- Тайлант онд зээлийн хүүгийн орлого 20 214.8 мянган төгрөгийн тооцож бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.4 *"Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх."* заалтыг зөрчсөн.

Эрсдэлүүд

- Орлогын буруу ангилан бүртгэх;
- Хөрөнгө дутагдах;
- Санхүүгийн тайланд орлогыг бүрэн тусгаагүй байх;
- Дансны бичилт буруу хийсэн байх;
- Тооцоо, тооцооллыг буруу хийсэн байх;

НТАГ-ын зөвлөмж

- Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4 дүгээр зүйл. Хоршооны эрх, үүрэг 4.5 заалтыг хэрэгжүүлж ажиллах;
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2.1.4 заалтыг мөрдөж ажиллах;

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн шууд захирагчийн зүгээс хүүгийн орлогыг санхүүгийн тайланд бүртгэсэн, зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах хариу ирүүлсэн болно.

Асуудал 2: Бараа материал

Тэргүүлэх ач олбогдол №1

НТАГ-ын ажиглалт

- Ашиглалтанд байгаа 4 нэр төрлийн 111.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын

НТАГ-ын зөвлөмж

- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-

2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх.” заалтыг зөрчсөн;

ын 2.1.4 заалтыг мөрдөж ажиллах;

- Бараа материалын дансанд 1 076.7 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” дахь заалтыг зөрчсөн;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 заалтыг мөрдөж ажиллах;

Эрсдэлүүд

- Бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй байх;
- Хөрөнгө дутагдах;
- Хөрөнгийг буруу ангилалан бүртгэсэн байх;

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

- Төсвийн шууд захирагчийн зүгээс алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах хариу ирүүлсэн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

Хянасан:
Дэд дарга, тэргүүлэх аудитор

санхүүгийн аудитын II хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Бэлтгэсэн:

Ахлах аудитор



Б.Баттуяа

Ц.Бат-Өлзий

Д.Энхдалай

2018 оны 2 дугаар сарын 13

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14 436 354 728,16	14 427 029 112,77
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ	569 103,00	0,00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	569 103,00	-
31110	Төгрөг	569 103,00	-
33	АВЛАГА	14 425 632 675,16	14 207 822 298,77
33400	Зээлийн хүүгийн авлага	114 797 675,16	41 022 298,77
335	Бусад авлага	14 310 835 000,00	14 166 800 000,00
3351	Байгууллагаас авах авлага	14 310 835 000,00	14 166 800 000,00
34	УРЬДЧИЛГАА	-	194 448 080,00
34600	Урьдчилж гарсан зардал	-	194 448 080,00
35	БАРАА МАТЕРИАЛ	10 152 950,00	24 758 734,00
354	Хангамжийн материал	10 152 950,00	24 758 734,00
35410	Бичиг хэргийн материал	1 598 000,00	2 355 800,00
35420	Аж ахуйн материал	5 899 300,00	10 167 284,00
35430	Сэлбэг хэрэгсэл	333 900,00	333 900,00
35440	Түлш шатах тослох материал	750 000,00	-
35450	Барилгын засварын материал	232 750,00	232 750,00
35470	Бусад хангамжийн материал	1 339 000,00	11 669 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	145 528 298,58	180 391 000,50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	145 528 298,58	180 391 000,50
392	Биет хөрөнгө	110 672 965,29	112 936 667,25
39203	Авто тээврийн хэрэгсэл	99 201 200,00	89 201 200,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80 617 616,77)	(85 484 483,49)
39205	Машин, тоног төхөөрөмж	63 482 300,00	71 194 300,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49 430 591,97)	(57 208 858,45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47 180 458,10	37 773 697,20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28 030 887,80)	(24 193 727,34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	190 515 050,00	222 173 550,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(131 626 946,27)	(140 519 010,67)
393	Биет бус хөрөнгө	34 855 333,29	67 454 333,25
39301	Програм хангамж	43 650 000,00	74 630 000,00
39302	Хасагдуулга	(8 794 666,71)	(20 175 666,75)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	13 000 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	14 581 883 026,74	14 607 420 113,27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	14 900 065,15	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14 900 065,15	-
413	Өглөг	14 900 065,15	-
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг	6 470 270,00	-
4136	Бусад өглөг	8 429 795,15	-
41361	Байгууллагад төлөх өглөг	7 853 692,15	-
41362	Хувь хүмүст төлөх өглөг	576 103,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	14 566 982 961,59	14 607 420 113,27

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

51	Засгийн газрын хувь оролцоо	14 566 982 961,59	14 607 420 113,27
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	68 819 274,70	68 819 274,70
51101	Өмч: -Төрийн өмч	68 819 274,70	68 819 274,70
512	Хуримтлагдсан үр дүн	14 497 576 890,86	14 538 175 816,21
51210	Өмнөх үеийн үр дүн	14 497 576 890,86	14 497 738 664,53
51220	Тайлант үеийн үр дүн	-	40 437 151,68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	586 796,03	425 022,36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	14 581 883 026,74	14 607 420 113,27

Аудит хийгдсэн үр дүнгийн тайлан

/төгсгөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3 836 259 723,52	1 004 167 303,09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73 954 110,00	307 373 916,09
120	Нийтлэг татварын бус орлого	73 954 110,00	307 373 916,09
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	73 954 110,00	307 373 916,09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68 904 110,00	59 365 076,09
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5 050 000,00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	248 008 840,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3 762 305 613,52	696 793 387,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44 380 113,52	2 304 000,00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	31 448 000,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6 785 600,00	2 304 000,00
131106	Төсвийн урамшуулал	6 146 513,52	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	226 835 000,00	694 489 387,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226 835 000,00	694 489 387,00
132005	Хөрөнгийн санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3 491 090 500,00	-
1330	Төсвийн захирагчдаас	3 491 090 500,00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	502 178 960,81	810 752 439,22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359 808 273,42	523 613 254,45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359 808 273,42	523 613 254,45
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	185 306 835,28	191 550 655,80
210101	Цалин	150 786 817,28	191 550 655,80
210102	Нэмэгдэл цалин	21 627 116,00	-
210105	Гэрээтийн цалин	12 892 902,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22 164 821,00	17 607 043,86
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	14 850 359,00	11 218 227,00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1 473 952,00	1 480 289,00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1 825 159,00	1 398 640,00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	365 031,00	319 080,86
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3 650 320,00	3 190 807,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 315 000,00	-
210304	Байрны түрээс	3 315 000,00	-

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2104	Хангамж, бараа материалын зардал	58 149 231,83	22 618 538,05
210401	Бичиг хэргийн материал	17 496 070,00	5 637 501,00
210402	Тээвэр, шатахууны зардал	12 944 783,00	4 977 217,00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	7 390 978,83	6 516 820,05
210404	Ном, хэвлэлийн зардал	20 317 400,00	-
210408	Бараа материал актасны зардал	-	5 487 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	330 000,00	-
210604	Урсгал засвар	330 000,00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3 102 650,00	238 349 700,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3 102 650,00	238 349 700,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87 439 735,31	53 487 316,74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19 741 531,28	5 118 890,85
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	2 210 180,00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65 488 024,03	48 368 425,89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142 370 687,39	287 139 184,77
2132	Бусад урсгал шилжүүлэг	50 899 791,00	50 072 722,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44 990 000,00	20 073 940,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22 905 679,00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5 909 791,00	7 093 103,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81 678 296,39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81 678 296,39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9 792 600,00	237 066 462,77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 792 600,00	237 066 462,77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	3 334 080 762,71	193 414 863,87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	152 977 712,19
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1 889 372,19
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	151 088 340,00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(152 977 712,19)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	3 334 080 762,71	40 437 151,68

Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Итгэргэгээр!

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3 900 153 054,42	970 933 839,48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137 847 440,90	274 140 452,48
120	Нийтлэг татварын бус орлого	137 847 440,90	274 140 452,48
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	137 847 440,90	274 140 452,48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124 467 440,90	274 140 452,48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13 380 000,00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3 762 305 613,52	696 793 387,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44 380 113,52	2 304 000,00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	31 448 000,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6 785 600,00	2 304 000,00

НТАГ-2018/228/СТА-ТШЗ

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

131106	Төсвийн урамшуулал	6 146 513,52	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3 717 925 500,00	694 489 387,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	226 835 000,00	694 489 387,00
132005	Хөрөнгийн санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3 491 090 500,00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	3 890 595 951,42	962 190 942,48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3 890 595 951,42	962 190 942,48
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271 652 487,03	662 226 004,71
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	175 429 498,76	194 138 669,51
210101	Үндсэн цалин	110 860 198,76	143 804 269,51
210102	Нэмэгдэл	30 567 700,00	35 330 400,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 801 600,00	15 004 000,00
210105	Гэрээт ажлын хөлс	24 200 000,00	-
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	25 446 213,52	21 489 300,00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25 446 213,52	21 489 300,00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	3 315 000,00	-
210304	Байрны түрээс	3 315 000,00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	17 961 293,47	18 245 580,20
210401	Бичиг хэрэг	5 056 210,00	5 139 851,00
210402	Тээвэр, шатахуун	5 964 833,00	6 588 909,15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6 790 250,47	6 516 820,05
210404	Ном, хэвлэл	150 000,00	-
210604	Урсгал засвар	330 000,00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 102 650,00	422 132 580,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3 102 650,00	422 132 580,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46 067 831,28	6 219 875,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32 937 831,28	6 219 875,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	13 130 000,00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 618 943 464,39	299 964 937,77
2132	Бусад урсгал шилжүүлэг	3 527 472 568,00	62 898 475,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	3 514 990 500,00	31 403 590,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22 905 679,00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12 482 068,00	8 589 206,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	81 678 296,39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	81 678 296,39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9 792 600,00	237 066 462,77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9 792 600,00	237 066 462,77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	9 557 103,00	8 742 897,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8 988 000,00	9 312 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8 988 000,00	9 312 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	8 988 000,00	9 312 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8 988 000,00	9 312 000,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(8 988 000,00)	(9 312 000,00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	569 103,00	(569 103,00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	569 103,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	569 103,00	0,00

Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мөгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ ДҮН
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	68 819 274,70	586 796,03	14 497 576 890,86	14 566 982 961,59
Нагтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	161 773,67	161 773,67
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68 819 274,70	586 796,03	14 497 738 664,53	14 567 144 735,26
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	161 773,67	-	161 773,67
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	40 437 151,68	40 437 151,68
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	68 819 274,70	425 022,36	14 538 175 816,21	14 607 420 113,27

Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 465 076 500,00	732 199 829,71	732 876 670,29	50,0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1 465 076 500,00	732 199 829,71	732 876 670,29	50,0
210	Бараа, үйлчилгээний зардал	1 243 070 500,00	659 989 354,71	583 081 145,29	53,1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195 359 200,00	194 138 669,51	1 220 530,49	99,4
210101	Үндсэн цалин	145 024 800,00	143 804 269,51	1 220 530,49	99,2
210102	Нэмэгдэл	35 330 400,00	35 330 400,00	-	100,0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	15 004 000,00	15 004 000,00	-	100,0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 489 300,00	21 489 300,00	-	100,0
210201	Тэтгэврийн даатгал	21 489 300,00	21 489 300,00	-	100,0
2104	Хангамж, бараа материалын зардал	17 124 000,00	18 245 580,20	(1 121 580,20)	106,5
210401	Бичиг хэрэг	5 200 000,00	5 139 851,00	60 149,00	98,8
210402	Тээвэр (шатахуун)	5 100 000,00	6 588 909,15	(1 488 909,15)	129,2
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6 824 000,00	6 516 820,05	307 179,95	95,5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1 004 098 000,00	422 132 580,00	581 965 420,00	42,0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 004 098 000,00	422 132 580,00	581 965 420,00	42,0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	5 000 000,00	3 983 225,00	1 016 775,00	79,7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5 000 000,00	3 983 225,00	1 016 775,00	79,7
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	222 006 000,00	72 210 475,00	149 795 525,00	32,5
2132	Бусад урсгал шилжүүлэг	222 006 000,00	72 210 475,00	149 795 525,00	32,5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	187 923 900,00	40 715 590,00	147 208 310,00	21,7
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23 082 100,00	22 905 679,00	176 421,00	99,2
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	11 000 000,00	8 589 206,00	2 410 794,00	78,1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 459 076 500,00	731 630 726,71	727 445 773,29	50,1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 271 152 600,00	457 490 274,23	813 662 325,77	36,0
132001	Орон нутгийн төсвөөс	1 271 152 600,00	457 490 274,23	813 662 325,77	36,0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	187 923 900,00	274 140 452,48	(86 216 552,48)	145,9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81 000 000,00	274 140 452,48	(193 140 452,48)	338,4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	106 923 900,00	-	106 923 900,00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	569 103,00	(569 103,00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0,00	(0,00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-	100,0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100,0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	-	100,0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100,0

2017 оны нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2 236 650,00	(2 236 650,00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.Нотлох баримтын мэдээлэл




Нотлох баримтын бүрдэл			
Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
Үр дүнгийн урамшууллыг илүү тооцсон, шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон /баримтат, дүн шинжилгээний/			

3.Акт(албан шаардлага)тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан болон хариуцагчийн мэдээлэл

Акт(албан шаардлага)тогтоосон Төрийн аудитын байгууллагын ажилтан			Хариуцагч			
Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Танилцаж,зөвшөөрсөн гарын үсэг
Д.Энхдалай	Ахлах аудитор		Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	дарга	П.Батхүлэг	
				Нягтлан бодогч	Б.Батбаатар	

4.Акт(албан шаардлага)тогтоох үеийн хяналт

4.1Эхний хяналтын бүртгэл

№	Хяналт хийсэн албан тушаалтан	Хянасан огноо	Хяналтаар зөвлөмж өгсөн	Хянасан ажилтны гарын үсэг
1	Хэлстийн дарга бөгөөд Аудитын менежер	2018.02.12.		
2	Дэд дарга, Тэргүүлэх аудитор	2018.2.12		
3	Хуулийн ажилтан			

4.2 Хяналтын баталгаажуулалт-Хэвлэмэл хуудсанд хэвлэх эрх

№	Баталгаажуулсан	Зөвшөөрсөн огноо	Баталгаажуулсан гарын үсэг ба хурлын шийдвэр
1	Тэргүүлэх аудитор		
2	Удирдлагын зөвлөлийн хурал		

Акт, албан шаардлагын бүртгэл, хяналтын хуудас

Акт(албан шаардлага) тогтоох үеийн бүртгэл, хяналт

1. Үндсэн мэдээлэл

Аудитын нэр	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	Аудитын код	НТАГ-2018/228/СТА-ТШЗ
-------------	--------------------------------------	-------------	-----------------------

Акт/албан шаардлага/-ын дугаар	Тогтоосон огноо	2018.02.12	Мөнгөн дүн / төгрөгөөр/	13 157.4
--------------------------------	-----------------	------------	-------------------------	----------

Акт/албан шаардлага/тогтоосон үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих	Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлогыг төвлөрүүлээгүй.			
	Зөрчсөн эрх зүйн заалт	Нэр	"Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"		
		Заалт	<ul style="list-style-type: none"> "Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4. Хоршооны эрх, үүрэг, 4.5 дахь заалт; 		
	Акт/албан шаардлага тогтоох эрх зүйн үндэслэл	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам;		
		Заалт	3.1 Аудитаар орлого бүрдүүлэх, зарцуулах, өмч, хөрөнгө бэлтгэх, ашиглах, хадгалах харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актууд болон гэрээ, хэлцлийн нөхцлийг мөрдөөгүйгээс илэрсэн дараах зөрчилд төрийн аудитын байгууллага акт тогтооно.		


Актын төлбөр барагдуулах дүн	Улсын төсвийн дансанд		Зөрчил арилгах огноо 2018.05.01.
	Орон нутгийн төсвийн дансанд	13 157.4 мянган төгрөг	
	Тухайн байгууллагын дансанд		

2. Актын биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга П.Батхүлэг, нягтлан бодогч Б.Батбаатар нарт даалгав.

АКТ

ТОГТООСОН¹:

АХЛАХ АУДИТОР



Д.ЭНХДАЛАЙ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

П.БАТХҮЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

ХЯНАСАН:

**САНХҮҮГИЙН АУДИТЫН II
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР**



Ц.БАТ-ӨЛЗИЙ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариушлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

2. Актын биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга П.Батхүлэг, нягтлан бодогч Б.Батбаатар нарт даалгав.


АКТ

ТОГТООСОН¹:

ЗӨВШӨӨРСӨН:

АХЛАХ АУДИТОР

ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



Д.ЭНХДАЛАЙ

П.БАТХҮЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ
Б.БАТБААТАР

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН II
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.БАТ-ӨЛЗИЙ


¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

2. Актын биелэлтийг 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга П.Батхүлэг, нягтлан бодогч Б.Батбаатар нарт даалгав.

АКТ

ТОГТООСОН¹:

АХЛАХ АУДИТОР



Д.ЭНХДАЛАЙ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

П.БАТХҮЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТБААТАР

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН II
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР



Ц.БАТ-ӨЛЗИЙ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 01/10

Улаанбаатар хот

НТАГ-2018/228/СТА-ТЧЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлого 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг төвлөрүүлээгүй нь Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4 дүгээр зүйл хоршооны эрх, үүрэг 4.5-д "Сангийн эх үүсвэрийн хүүг байршуулсан хөрөнгийн дүнгээс жилийн 1%-иар тооцож, эх үүсвэр байршуулснаас хойш сар бүр хүүг тооцож дараа сарын 05-ны дотор төлнө." заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 95 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын Гурав. Акт тогтоох үндэслэл, түүний бүтэц 3.1.1 "Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан, хөтөлбөр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төвлөрүүлээгүй хүүгийн орлого нийт 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын Нийслэлийн төрийн сан банк дахь 100200051039 тоот дансанд 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор төвлөрүүлэх;



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 01/10

Улаанбаатар хот

НТАГ - 2018/228/СТА - ТУЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлого 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг төвлөрүүлээгүй нь Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4 дүгээр зүйл хоршооны эрх, үүрэг 4.5-д "Сангийн эх үүсвэрийн хүүг байршуулсан хөрөнгийн дүнгээс жилийн 1%-иар тооцож, эх үүсвэр байршуулснаас хойш сар бүр хүүг тооцож дараа сарын 05-ны дотор төлнө." заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 95 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын Гурав. Акт тогтоох үндэслэл, түүний бүтэц 3.1.1 "Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан, хөтөлбөр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төвлөрүүлээгүй хүүгийн орлого нийт 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын Нийслэлийн төрийн сан банк дахь 100200051039 тоот дансанд 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор төвлөрүүлэх;



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 01/10

Улаанбаатар хот

НТАГ-2018/228 /СГА-ТМЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бичил зээлийг дамжуулан зээлдүүлэгч 34 хоршоо 2017 оны хүүгийн орлого 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг төвлөрүүлээгүй нь Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сангаас зээл олгоход хамтран ажиллах гэрээ"-ний 4 дүгээр зүйл хоршооны эрх, үүрэг 4.5-д "Сангийн эх үүсвэрийн хүүг байршуулсан хөрөнгийн дүнгээс жилийн 1%-иар тооцож, эх үүсвэр байршуулснаас хойш сар бүр хүүг тооцож дараа сарын 05-ны дотор төлнө." заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 95 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын Гурав. Акт тогтоох үндэслэл, түүний бүтэц 3.1.1 "Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан, хөтөлбөр, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төвлөрүүлээгүй хүүгийн орлого нийт 13 157 400.00 /Арван гурван сая нэг зуун тавин долоон мянга дөрвөн зуун/ төгрөгийг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын Нийслэлийн төрийн сан банк дахь 100200051039 тоот дансанд 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор төвлөрүүлэх;





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018.02.12 № 237

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
П.БАТХҮЛЭГ ТАНАА

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрхийн хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийсэн.

Аудитаар санхүүгийн тайланд илэрсэн 13 157.4 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосныг хүргүүллээ.

Төлбөрийн актыг тогтоосон хугацаанд барагдуулж, хариу ирүүлнэ үү.

ДЭД ДАРГА  БАТТУЯА

